Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгөгдсөн зөвлөмж байхгүй болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 46 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар нь хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийг ханган мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, экспортын баримжаатай бүтээгдэхүүний үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилго тавин ажиллаж Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлого, хөтөлбөр, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэн, мал аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэр, хөнгөн, хүнс, хоол үйлдвэр, хоршооны салбарын үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулах, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнсээр хангаж төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх төрийн байгууллага юм.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Энэ нь жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг тооллогын комисс хийгээгүй, хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж ажиллах үүргээ биелүүлээгүй, 3,580.8 мянган төгрөгийн шатахууны талон нөөцөлсөн, Монгол Улсын Засгийн Газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар нь Хүнс, Хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 2019 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн А/385 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дотоод хяналт шалгалтын зөвлөл байгуулж журам, төлөвлөгөө батлах тухай газрын даргын 2021 оны 4 дүгээр сарын 16-ны А/12 тушаалаар 4 зорилго 24 хэрэгжүүлэх арга хэмжээтэй төлөвлөгөөг боловсруулан баталсан байна.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дотоод үйл ажиллагааны төлөвлөгөө нь 4 зорилго 24 хэрэгжүүлэх арга хэмжээтэй батлагдан төлөвлөгөөний үр дүнд хүрсэн 22 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн 2 арга хэмжээ биелэлт 98.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт Хүнс, Хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны А/308 албан бичгийн дагуу Санхүү, хөрөнгө оруулалтын газрын төсвийн гүйцэтгэл тайлан хөтөлбөр арга хэмжээ хариуцсан ахлах мэргэжилтнээр ахлуулсан ажлын хэсэг байгууллагын 2021 оны төсвийн гүйцэтгэл өмнөх оны аудитын дүгнэлт, акт албан шаардлагын биелэлт үйл ажиллагаатай танилцан үүрэг чиглэл өгч мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангасан байна.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зарлагын 1,184,272.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 17,764.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13,323.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлага зөрүү их байгаа тул дахин тооцох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуульж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

#### ***Орлого:***

Тус байгууллага 2021 онд улсын төсвөөс 443,281.3 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 162.6 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 19,671.0 мянган төгрөг нийт 463,114.9 мянган төгрөг өмнөх оноос 505,503.6 мянган төгрөгөөр буюу 52.2 хувиар буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгөөс шалтгаалжээ.

#### ***Зардал :***

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 499,738.6 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 463,699.3 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 433,705.3 мянган төгрөг зарцуулсан байна.

#### ***Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:***

Тус байгууллага төрийн сангийн 100140019003 тоот дансанд 2021 онд 444,201.3 мянган төгрөгийн орлого, 444,201.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Нэмэлт санхүүжилтийн 100140019401 тоот дансаар 19,671.0 мянган төгрөгийн орлого, 19,671.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Төрийн банкин дах 310000579492 дансны үлдэгдэл 7.0 мянган төгрөг зарлагын гүйлгээ хийгдэж 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг болж данс хаагдсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/ Өөрчлөлт
			3=2-1
Б	1	2	
Мөнгөн хөрөнгө	7.0	0	-7.0
Авлага	4,624.0	2,064.0	-2,560.0
Урьдчилгаа	0	7200.0	-7200.0
Бараа материал	78,121.7	80,638.5	2,516.8
Үндсэн хөрөнгө	547,679.9	511,286.3	-36,393.6
Нийт хөрөнгө	630,432.6	601,188.8	-29,243.8
Өр төлбөр		180.0	-180.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	630,432.6	601,188.8	-29,243.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	630,432.6	601,188.8	-29,243.8

Авлага дансны үлдэгдэл 2,064.0 мянган төгрөг болж 2,560.0 мянган төгрөгөөр буурсан нь хувь хүмүүсээс авах авлагыг барагдуулснаас шалтгаалжээ. Авлагын үлдэгдэл 180.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн татаас санхүүжилтийн авлага байна. Урьдчилгаа дансны үлдэгдэл 7,200.0 мянган төгрөг болж нэмэгдсэн нь Дата ланд технологи ХХК-д програмын лицензын төлбөр урьдчилж шилжүүлсэнээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 80,638.5 мянган төгрөг болж 2,516.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бараа материал худалдан авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 511,286.3 мянган төгрөг болж 36,393.6 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 593,808.8 мянган төгрөг болж 36,443.8 төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 635,704.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 635,704.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 231,437.1 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 404,267.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь цалин хөлс, НДШ-ийн зардал 72,433.8 мянган төгрөг, байр ашиглах тогтмол зардал 26,179.6 мянган төгрөг, хангамжийн материалын зардал 41,712.2 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардал 15,111.4 мянган төгрөг, дотоод албан томилолт, сургалт семинарын зардал 76,000.1 мянган төгрөгөөр тус тус бууруулсанаас шалтгаалжээ.

Хүнс, Хөдөө Аж Ахуйн Хөнгөн Үйлдвэрийн Яамнаас Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын төсвийн хуваарийг, 2021 оны 11 дүгээр сард тодотгон 443,281.3 мянган төгрөг буюу 39,014.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж ирүүлсэн байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 443,281.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 443,281.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 443,281.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 740.0 мянган төгрөг нийт 444,021.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 433,705.3 мянган төгрөгийг зарцуулж, 10,316.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 433,705.3 мянган төгрөг буюу 97.67 хувьтай байгаа нь 10,316.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар тайлант онд 19,671.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлж, томилолтын зардалд 232.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 11,922.0 мянган төгрөг, бусад зардалд 7,517.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт Хүнс, Хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас тайлант онд мал аж ахуйн өвөлжилт, отрын бүс нутаг эргэх шатахуун томилолтын зардалд 3,800.0 мянган төгрөг, аймгийн ургацын штабын шатахуун, томилолтын зардалд 12,000.0 мянган төгрөг, худалдааны 100 жилийн ой тэмдэглэн өнгөрүүлэх, ахуйн үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын зардалд 3,810.0 мянган төгрөг, мэдээлэл технологийн зардалд 10,800.0 мянган төгрөг, түлш халаалтын зардал 24,085.7 мянган төгрөгөөр тус тус 2021 оны батлагдсан төсвийн хувиарт өөрчлөлт оруулан тодотгон ирүүлсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар Дата ланд технологи ХХК-д төсвийн төслийн программын 2022, 2023 онуудын лицензын төлбөрт 7,200.0 мянган төгрөг, ажлын дүрэмт хувцас худалдан авахад 1,939.0 мянган төгрөг, албан томилолтын зардалд 2,496.0 мянган төгрөг, Худалдааны 100 жилийн ой тэмдэглэн өнгөрүүлэхэд 1,260.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/47 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй томилогдсон тооллогын комисс жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй, хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 132 мэдээллээс хугацаандаа оруулсан 95 мэдээлэл, хугацаа хоцроосон 36 мэдээлэл, мэдээлээгүй 1 мэдээлэл байна. Тус байгууллага 5,0 саяас дээших орлогын 16, зарлагын 6 гүйлгээ байршуулж, 5,0 саяас дээших худалдан авалтын 21 гүйлгээ байршуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар нь Монгол Улсын Засгийн Газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг зөрчиж Дата ланд технологи ХХК-д төсвийн төслийн программын 2022, 2023 онуудын лицензын төлбөрт 7,200.0 мянган төгрөг, ажлын дүрэмт хувцас худалдан авахад 1,939.0 мянган төгрөг, албан томилолтын зардалд 2,496.0 мянган төгрөг, худалдааны 100 жилийн ой тэмдэглэн өнгөрүүлэх шагналд 1,260.0 мянган төгрөг нийт 12,895.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим сайтад мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж мэдээлэх, хууль тогтоомжийн хэрэгжилт, санхүүгийн программтай холбоотой 3 зөвлөмж өгөгдсөнөөс 2 зөвлөмжийг 66.6%-тай хэрэгжүүлэн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 216 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна. Санхүүгийн динамик программтай холбоотой зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын санхүүгийн тайлангийн дараагийн аудитаар хөрөнгийн тооллого, шатахууны талон авч нөөц бүрдүүлсэн эсэхийг авч үзэх.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,569,451.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,073,713.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 9,139.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 486,598.4 мянган төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

### 4.2.1 Залруулсан алдаа

1.Тус байгууллага жилийн эцсийн санхүүгийн тайланг цаасаар ирүүлэхдээ төсвийн гүйцэтгэлээр зарцуулсан 443,281.3 мянган төгрөгийг тайлагнаж ирүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2.Тус байгууллага өмчийн өөрчлөлтийн тайлангийн эхний үлдэгдэл цаасаар ирүүлсэн тайланд 630,432.6 мянган төгрөг, СТАУС-аар ирсэн өмчийн өөрчлөлтийн тайланд 1,260,865.1 мянган төгрөг буюу 630,432.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

## 4.2.2 Төлбөрийн акт

1. Тус байгууллага тайлант онд Засгийн Газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалтыг зөрчин ажлын дүрэмт хувцасны зардалд 1,939.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудыг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Тус байгууллага Дата ланд технологи ХХК-д төсвийн төслийн программын 2022, 2023 онуудын лицензын төлбөрт 7,200.0 мянган төгрөг шилжүүлж зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудыг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

## 4.2.3 Албан шаардлага

1. Тус байгууллага тайлант онд Засгийн Газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.6 дах заалтыг зөрчин Худалдааны 100 жилийн ой тэмдэглэж шагналд 1,260.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудыг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

2. Төв аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/47 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй томилогдсон тооллогын комисс жилийн эцсийн 426,417.8 мянган төгрөгийн хөрөнгийн тооллого хийгээгүй, хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах үүргээ биелүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дүгээр зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйл болон санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

3. Тус байгууллага тайлант онд 3,580.8 мянган төгрөгийг улсын төсвийн дансанд татан төвлөрүүлэхгүйгээр шатахууны талон авч нөөц бэлтгэж үлдэгдэлтэй гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ” гэсэн заалтуудыг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

4.Тус байгууллагад ашиглагдаж байгаа санхүүгийн “Динамик” программыг сайжруулах талаар өмнөх онд зөвлөмж өгсөн ч хэрэгжүүлээгүй, татагдсан санхүүгийн тайлангийн СТАУС шаардлага хангахгүй, үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн өмнөх оны болон тайлант оны үзүүлэлтүүд алдаатай татагдсан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө, гүйцэтгэл төгрөг, мянган төгрөгөөр хольж татсан зэрэг зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан Бодох Бүргэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 17 дугаар зүйлийн 17.1.11-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвшөөрөгдсөн програм хангамжийг нийтэд мэдээлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь:Албан шаардлага өгөв.

5. Худалдан авалт бүрд ө баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар баталгаажсан эсэхийг тулган шалгахад 52,843.8 мянган төгрөгийн 20 байгууллагын гүйлгээ ө баримтаар баталгаажаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QRкодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Шийдвэрлэсэн нь:Албан шаардлага өгөв.

6.Тус байгууллага тайлант онд Засгийн Газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.5 дах заалтыг зөрчин томилолтын зардалд 2,496.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтуудыг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

- Шийдвэрлэсэн нь:Албан шаардлага өгөв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулах асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Хүнс, Хөдөө аж ахуйн газар	10	1,569,451.3	2	1,073,713.9	2	9,139.0	6	486,598.4		

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70272287  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)